



БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС ДАХЬ
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 4/18

Сөүл хот

Ажил дүгнэх журам батлах тухай

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/157 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв"-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалт, 3.5 дахь заалт, төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан ажилдаа идэвхи зүтгэлтэй ажиллаж, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан ажилчин албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний үр дүнг улирал, хагас ба бүтэн жилийн ажлыг дүгнэж, цалингийн урамшуулал олгохтой холбогдуулан журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг 2018 оны 06 дугаар сараас эхлэн мөрдлөг болгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төвийн санхүү, нягтлан бодох, тоо бүртгэл хариуцсан мэргэжилтэн /Ч.Түмэнжаргал/, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тасгийн дарга /Я.Энхбаясгалан/, Нийгмийн даатгалын тасгийн дарга /Б.Тэнүүн/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРМАНДАХ

000050

**Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
үйлчилгээний төвийн ажилчин албан хаагчдын ажил дүгнэх журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн ажилчин албан хаагчийн ажлыг дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2 Төвийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилчин албан хаагчдын хөдөлмөрийн гэрээг улирал, хагас жил, жилээр дүгнэн, шагнаж урамшуулахад энэхүү журмыг баримтална.

1.3 Ажилчин албан хаагчдын ажлыг дүгнэх нь тухайн ажилчин албан хаагч ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүргийг хэрхэн гүйцэтгэж байгааг үнэлж, үйл ажиллагааг сайжруулахад чиглэнэ.

1.4 Ажилчин албан хаагчдын ажлыг дүгнэхдээ шударга ил тод зарчмыг баримтална.

Хоёр. Ажилчин албан хаагчдын ажил дүгнэх

2.1 Ажилчин албан хаагчдын ажлыг хагас, бүтэн жилээр төвийн дарга дүгнэнэ.

2.2 Ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу ажилчин албан хаагчдын тайланг тасгийн дарга нар 06 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор төвийн удирдлагад өгнө.

Гурав. Ажлын үр дүнг дүгнэх аргачлал

Дараах шалгуур үзүүлэлт тус бүрт 5-10 хүртэл оноог өгч дүгнэнэ.

3.1 Мэргэжлийн ур чадварын дадлага туршлага: Шинэчлэлт өөрчлөлт хийх эрмэлзэл бүтээлч санал дэвшүүлэх, оновчтой шийдвэр гаргах чадвар

3.2 Үндсэн ажлын гүйцэтгэл: Ажлын байрны тодорхойлолтонд тусгагдсан ажил үүргийн биелэлт /Ажил үүргээ гүйцэтгэх явцад боловсруулсан бичиг баримтын хөтлөлт/

3.3 Төлөвлөгөөний биелэлт: Улирал, жилийн ажлын тайлан, мэдээний чанар хугацаа

3.4 Хөдөлмөрийн гэрээний биелэлт: Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, Хөдөлмөрийн хууль болон гэрээг зөрчиж сахилгын хариуцлага хүлээсэн эсэх

3.5 Үүрэг даалгавар: Дээд шатны байгууллага, төвийн удирдлага, тасгийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь хэрхэн биелүүлсэн байдал

3.6 Идэвх оролцоо: Байгууллагаас зохион байгуулсан болон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцсон байдал

3.7 Санаачлага: Шинээр санаачилж хийсэн ажил, үр дүн

3.8 Ажлын цаг ашиглалт: Ажил тасалсан, хоцорсон болон ажлын цагаар хийж гүйцэтгэсэн ажлын бүтээмж чанар

3.9 Эд хөрөнгийн ашиглалт: Хариуцаж буй эд аж ахуйг хэрхэн эзэмшиж байгаа байдал

3.10 Тасгийн дарга нарын үнэлгээ: Тухайн тасаг хариуцсан даргын үнэлгээ

а/ 90-100 оноо авсан бол А үнэлгээ буюу шаардлагаас үлэмж дээгүүр

б/ 75-89 оноо авсан бол В үнэлгээ буюу шаардлагаас дээгүүр

в/ 60-74 оноо авсан бол С үнэлгээ буюу шаардлага хангаж байгаа

г/ 0-59 оноо авсан бол D шаардлага бүрэн хангахгүй буюу хангалтгүй

D үнэлгээ авсан ажилчин албан хаагчдад даргын тушаалаар арга хэмжээ авч, ажлаа сайжруулах хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллуулна.

Дөрөв. Шагнал урамшуулал хариуцлага

4.1 Шаардлагаас үлэмж дээгүүр авсан ажилчин албан хаагчдыг үндсэн цалингийн 80%-100%-тай тэнцэх цалингийн урамшуулал олгох.

4.2 Шаардлагаас дээгүүр үнэлгээ авсан ажилчин албан хаагчдад үндсэн цалингийн 40%-70%-тай тэнцэх цалингийн урамшуулал олгох.

4.3 Шаардлага хангаж байгаа үнэлгээ авсан ажилчин албан хаагчдад үндсэн цалингийн 20%-40%-тай тай тэнцэх цалингийн урамшуулал олгох.

4.4 Шаардлага бүрэн хангахгүй буюу хангалтгүй үнэлгээ авсан ажилтанд сануулах, цалин хөлсийг бууруулах, ажлаас чөлөөлөх арга хэмжээ авах.